



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/12

Шивээговь сум


Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын 4.2, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Нээлттэй Говьсүмбэр" хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. "Шинээр шилжин ирж буй төрийн албан хаагчдыг түрээсийн байраар хангах хэлбэрээр дэмжлэг үзүүлэх журам"-ыг 1 дүгээр, түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Л.Бадамханд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Шивээговь сумын Засаг даргын 2025 оны
01-р сарын 21-ны өдрийн 7/12 дугаар
захирамжийн 1-р хавсралт



31

ШИНЭЭР ШИЛЖИН ИРЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ ТҮРЭЭСИЙН БАЙРААР ХАНГАХ ХЭЛБЭРЭЭР ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад /ЗДТГ-ын газар, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цагдаа, соёл урлаг/ нэн шаардлагатай, дутагдалтай байгаа ажлын байранд ажиллахаар шилжин ирсэн төрийн албан хаагчдад түрээсийн байраар дэмжлэг үзүүлэх харилцааг зохицуулна.
- 1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.
- 1.3. Дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", Засгийн газрын 2022 оны "Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай" 419 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Нээлттэй Говьсүмбэр" хөтөлбөрийг тус тус үндэслэл болгоно.
- 1.4. Дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ тэгш, шударга, ил тод байх зарчмыг баримтална.
- 1.5. Орон нутагт дутагдалтай байгаа төрийн албан хаагчдын ажлын байрны судалгаа, жагсаалтыг сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн жил бүрийн 1 дүгээр сард багтаан гаргаж олон нийтэд мэдээллэнэ.

Хоёр. Дэмжлэгийн төрөл хэлбэр

- 2.1 Төрийн албан хаагчид олгох дэмжлэгт:
 - 2.1.1 ЗДТГ-ын Түрээсийн орон сууцыг төрийн албан хаагчдад түрээслэх;

Гурав. Дэмжлэг олгох шалгуур

- 3.1. Төрийн албан хаагчид:
 - 3.1.1. Орон нутагт шилжин ирж Улсын бүртгэлийн хэлтэс болон багийн Засаг даргад бүртгэлээ хийлгэсэн байх.
 - 3.1.2 Тухайн жилийн дутагдалтай ажлын байрны жагсаалтад багтсан Төрийн захиргааны албан хаагч нь сэлгэн болон шилжүүлэн ажиллах ажлын байранд ажиллах, Төрийн үйлчилгээний албан хаагчийн хувьд 1 жилээс дээш хугацаагаар ажилласан байна.
 - 3.1.3 Орон нутагт 5-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах /Ажил олгогчтой гэрээ байгуулна/.
 - 3.1.4 Эрүүгийн болон иргэний хэрэг маргаанд холбогдоогүй болон урьд нь ял шийтгэл эдлээгүй байх, шүүхийн шийдвэрээр бусдад өр зээлийн маргаангүй байх шаардлагатай.

**Дөрөв.Хүсэлт гаргахад бүрдүүлэх бичиг баримт,
хүлээн авах, бүртгэх, шийдвэр гаргах**

4.1. Хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлж, сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр уламжлан сумын Засаг даргад ирүүлнэ.

4.1.1. Төрийн албан хаагчийн хувьд:

4.1.1.1. Өргөдөл

4.1.1.2. Иргэний үнэмлэхний хуулбар /e-mongolia аппаас татаж авсан лавлагаа байж болно/

4.1.1.3. Оршин суугаа хаягийн тодорхойлолт /шилжин ирсэн байх/

4.1.1.4. Мэргэжлийн диплом, мэргэшүүлэх сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар.

4.1.1.5. Ажил олгогч байгууллагатай ажлын байрны талаар тохиролцсон нөхцөл, хөдөлмөрийн гэрээ, тушаал шийдвэрийн хуулбар.

4.1.1.6. Ажил олгогчийн тодорхойлолт

4.2. Төрийн албан хаагчийн хүсэлтийг тухайн оны 01 дүгээр сард багтаан сумын Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авч бүртгэн, сумын Засаг даргад танилцуулан, ажлын хэсгийн гишүүдтэй хамтран судалж, шийдвэрлүүлэн хэрэгжилтэд хяналт тавина.

4.3. Түрээслэгчээр шалгарсан төрийн албан хаагчийг гэрээнд заагдсан хугацаагаар тус байранд байлгах бөгөөд гэрээг зөрчсөн үйлдэл гаргасан, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаанаар, өөрийн хүсэлтээр түрээсийн байрнаас гарах хүсэлтээ өгсөн тохиолдолд тухайн үед нь түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг дахин явуулж болно.

Тав. Түрээсийн дэмжлэгийн төлбөр

5.1. Журмын 4.2-д заасан шийдвэр гарснаар сумын Засаг даргын Тамгын газар хүсэлт гаргагчийн дэмжлэгийг олгосноор дэмжлэгт хамрагдсан албан хаагч дараах байдлаар түрээсийн төлбөрийг төлнө.

5.1.1.1 Төрийн албан хаагчдад түрээсийн орон сууцыг түрээсэлж байгаа тохиолдолд сумын ажлын хэсгийн шийдвэр, холбогдох гэрээг үндэслэн Говьсүмбэр аймгийн Түрээсийн орлогын дансанд шилжүүлэх.


5.2. Дэмжлэгт хамрагдсан төрийн албан хаагчийн мэдээллийг нэгтгэн, тайлагнах үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

Долоо. Бусад

7.1. Дэмжлэгийг хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсан, дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан, түрээсийн байр олгогч этгээдтэй байгуулсан гэрээний заалт болон журмыг зөрчсөн тохиолдолд дэмжлэгийг цуцлана.

7.2. Дэмжлэг олгох үйл ажиллагаатай холбоотой гарсан маргааныг Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

Шивээговь сумын Засаг даргын 2025 оны
 01-р сарын 21-ны өдрийн 11 дугаар
 захирамжийн 2-р хавсралт



**ШИНЭЭР ШИЛЖИН ИРЖ БУЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
 ЗОРИЛГООР ТҮРЭЭСИЙН БАЙР ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН
 ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын Орлогч дарга

Гишүүд: Засаг даргын Тамгын газрын дарга

Санхүүгийн албаны дарга

Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Нийгмийн бодлогын асуудал хариуцсан
 мэргэжилтэн